

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

БҮТЭЦ, ОРОН ТОО ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАНИЛЦУУЛГА

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХМАД Б.БАТЦЭЦЭГ

- Дундговь аймаг дахь цагдаагийн газар нь хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, албаны сургалтыг чанаржуулах, алба хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх мэдлэг чадвартай боловсон хүчнээр хангах, бэхжүүлэх, алба хаагчдын эрх ашиг, нийгэм ахуйн эрэлт хэрэгцээг судлан тодорхой ажил зохион байгуулах, Хүний нөөцийг судлах, сургаж бэлтгэх, дадлагажуулах мэргэжил боловсролыг нь дээшлүүлэх, давтан сургах, алба хаагчдын дунд соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, сахилга ёс зүйг төлөвшүүлэн ажиллаж байна.



ЦЕГ-ЫН ДАРГЫН 2017.06.30-НЫ
ӨДРИЙН А/135 ТООТ ТУШААЛЫН 11
ДҮГЭЭР ХАВСРАЛТААР ТУС
ЦАГДААГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ,
ОРОН ТООГ БАТАЛСАН.

БҮТЭЦ, СХЕМ



Цагдаагийн
газрын хэмжээнд 55
офицер, 53 ахлагч,
энгийн 5, 113 нийт
алба хаагчтай
байхаар
шийдвэрлэсэн.

Удирдлага
/Офицер-3, бүгд -3/
д/х Ц.Сугаржав

Захиргааны удирдлагын тасаг
/6 офицер, 9 ахлагч, бүгд -15/
д/х Л.Баярсайхан

**Хөдөлмөрийн гэрээгээр
ажиллагсад энгийн-5**

Эрүүгийн цагдаагийн тасаг
/12 офицер, 5 ахлагч, бүгд -17 /
х/ч Б.Эрдэнэбилэг

**Эрдэнэдалай сум дахь
цагдаагийн хэсэг**
/3 офицер, 2 ахлагч,
бүгд-5 /
х/ч Б.Шинэбаяр

Мөрдөн байцаах тасаг
/4 офицер, бүгд -4 /
х/ч Ч.Амарбаяр

**Сумдын хэсгийн
төлөөлөгч, цагдаа**
/14 офицер, 13 ахлагч,
бүгд-27/

**Хэрэг бүртгэх тасаг /
офицер -2 бүгд -2 /**
д/х Б.Энхмандал

**Нийтийн хэв журам
хамгаалах тасаг**
/6 офицер, 15 ахлагч
бүгд-21/
х/ч Т.Розон

**Монгол банкны
гэрээт харуулын
цагдаа-4**

Замын цагдаагийн тасаг
/5 офицер, 5 ахлагч, бүгд -
10/
д/х О.Чинзориг

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ХЭМЖЭЭНД 55 ОФИЦЕР, 49 АХЛАГЧ, 4 ЭНГИЙН АЖИЛЧИН НИЙТ 108 АЛБА ХААГЧТАЙГААР АХЛАГЧИЙН СУЛ ОРОН 4, ЭНГИЙН 1 ТОО ДУТУУ АЙИ ОУФУАОУЭ ОУИ ОУО, НИЙТИЙН ОУА АЕОФÀÌ ÒÀÌ ÃÀÀÈÀÕ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ҮИ ÆÑҮÍ ҮҮФÀҮҮ АÈÀÈҮҮÈҮÍ ÀÆÈÈÈÀÆ ААЕÍ À.

Орон тоо

■ Баталсан ■ Одоо ажиллаж байгаа ■ Дутуу



НАСНЫ АНГИЛАЛ

- Ажилтан, алба хаагчдын 26 буюу 23.4 хувь нь 21-25, 40 буюу 36 хувь нь 26-30, 20 буюу 18 хувь нь 31-35, 10 буюу 9 хувь нь 36-40, 7 буюу 6.3 хувь нь 41-45 нас, 7 буюу 6.3 хувь нь 46-50 нас, 1 буюу 0,9 хувь нь 51-ээс дээш насны ажилтан алба хаагч байна.


БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

-
- Боловсролын түвшингээр авч үзвэл: 73 буюу 65.7 хувь нь дээд, 13 буюу 11.7 хувь нь тусгай дунд, 22.5 буюу 23.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, магистрын зэрэг хамгаалсан 9 алба хаагч байна.
-
-

АЖИЛЛАСАН ЖИЛ

- Цагдаагийн байгууллагад 1 жил хүртэл хугацаанд ажиллаж байгаа 9 буюу 8.1 хувь, 39 буюу 35.1 хувь 1-5 жил, 13 буюу 11.7 хувь 6-7 жил, 18 буюу 16.2 хувь 8-10 жил, 10 буюу 9 хувь 11-15 жил, 12 буюу 10.8 хувь 16-20 жил, 21-25 жил ажиллаж байгаа алба хаагч 10 буюу 9 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЛ:



■ Хүйс



СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ, НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

- Цагдаагийн газарт хэв журмын цагдаа, цагдаа жолоочийн ажлын байрны сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор 2018.12.18-2018.01.05 өдрүүдэд байгууллагын цахим хаяг, аймгийн Цоглог, Ард телевизээр зар явууллаа. Зарын дагуу ирсэн 11 иргэнийг судалж хамт олны хурлаар оруулан хэлэлцэж болзол шаардлага хангасан 7 иргэнийг мэргэжлийн сонгон шалгаруулалтад иргэний материалыг ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж 5 иргэн тэнцэж 2 иргэнийг ажилд томилж 3 иргэн цагдаагийн анхан шатны дамжаанд суралцаж байна.

АЛБА ХААГЧДЫН САХИЛГА, ХАРИУЦЛАГА

2018 оны эхний 4 дүгээр сард 8 зөрчилд 10 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5 нэгж буюу 62.5 хувиар, сахилгын шийтгэл хүлээсэн хүний тоо 6 буюу 1.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчдын 3 нь офицер, 7 нь ахлагч байна. Албан тушаалаар нь ангилж үзвэл тасгийн дарга 1, эрүүгийн мөрдөгч 1, хэсгийн төлөөлөгч 1, Хэв журмын цагдаа 6, цагдаа зохицуулагч 1 байна. Зөрчлийг хэлбэрээр нь авч үзвэл ажил тасалсан 1, архидан согтуурсан 3, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 1, бусад зөрчил 3 бүртгэгдсэн.

АЛБА ХААГЧДЫН САХИЛГА, ХАРИУЦЛАГА

Сахилгын зөрчлийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цагдаагийн алба хаагч бие биедээ тавих зарчимч шаардлага сулаас шалтгаалсан 1, найз нөхдийн уруу таталт 1, хувь хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан 8 зөрчил үйлдэгдсэн байна. Зөрчлийг 100 хувь дотоодын хяналтаар илрүүлж цагдаагийн газрын даргын тушаалаар 5 алба хаагчид сануулах, 5 алба хаагчид албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан.

Цагдаагийн газрын хэмжээнд иргэд аж ахуй нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн үндэслэлээр 6, дотоодын хяналт шалгалтаар 3, эрүүгийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 2, удирдах албан тушаалтны шийдвэрээр 3 нийт 12 удаагийн албаны шалгалтад 14 алба хаагч холбогдон шалгагдаж цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж 4 алба хаагчийн цалинг бууруулж, 2 алба хаагчид холбогдох асуудлыг гэмт хэргийн шинжтэй гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар харъяаллын дагуу Авлигатай тэмцэх газарт материалыг хүргүүлж, 1 алба хаагчийг албанаас чөлөөлж, 2 алба хаагчид тушаалаар сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 5 алба хаагчид холбогдох асуудал нь тухайн алба хаагчдын буруутай үйлдэл тогтоогдоогүй байна. Албаны шалгалтыг хугацаанд нь 100 хувь шийдвэрлэж гомдол мэдээлэл өгсөн иргэн, албан тушаалтанд албан бичгээр хариу өгсөн байна.



АЛБАНЫ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Цагдаагийн газар нь 150 хүний багтаамжтай албаны сургалтын танхим, ширээ, сандал, техник хэрэгсэл, жагсаалын талбай, зориулалтын спорт заал, билиардны өрөөтэй.

Цагдаагийн газрын дотоод журамд заасны дагуу долоо хоног бүрийн лхагва гаригт албаны сургалтыг баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулдаг.



ЦЕГ-ын даргын А/08 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 онд явуулах сургалтын төлөвлөгөө”, сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварын дагуу 2018 зохион байгуулах албаны сургалтын саналыг тасаг албадаас авч сургалтын төлөвлөгөөг баталсан хуваарийн дагуу 2018 оны 04 дүгээр сарын байдлаар нэгдсэн сургалтад 12 удаа 551 алба хаагч, шинээр батлагдсан хууль тогтоомжийн сургалт 11 удаа 11 цаг 519 алба хаагч, бусад хууль тогтоомжийн сургалт 8 удаа 9 цаг 406 алба хаагч, Алба хаагчдыг хөгжүүлэх сургалт 2 удаа 2 цаг, 92 алба хаагч, бие бялдарын бэлтгэлжилтийн сургалт 11 удаа, 13 цаг, 309 алба хаагчийг тус хамруулан сургалтыг зохион байгуулаад байна. Сургалтын мэдээг баталсан загвар хүснэгтийн дагуу сар бүрийн 20-ны өдрөөр тасалбар болгон гаргаж ЦЕГ-ын Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлсэн.

- Сургалтаар олж мэдсэн мэдлэг чадварыг үнэлэх зорилгоор 3 удаагийн тестийн шалгалтыг авч үр дүнг тооцсон. Алба хаагчдын сургалтад оролцож буй идэвхи оролцоо, ирцийн байдлыг сарын эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгаж хэвшсэн. Алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтод албаны сургалтад хамрагдах үзүүлэлтийг нэмж оруулсан.
- Аймгийн Улаанзагалмайн нийгэмлэг, Онцгой байдлын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Монгол банк, аймгийн музей зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаас сургагч багш, мэргэжилтнүүдийг урьж алба хаагчдад сургалтыг явуулсан. Мөн ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвд сахилга ёс зүйн зөрчил гаргасан 3 алба хаагчийг төлбөртэй сургалтад хамруулсан. Эрхэлж буй ажлын чиглэлээр 11 алба хаагчийг давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулсан.



Цагдаагийн газрын сахилга, ёс зүйн зөвлөлийг 3 удаа хуралдуулж 21 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж батлуулсан. 2018 оны 01 дүгээр улирлын сахилга хариуцлагын зөвлөгөөнийг Эрүүгийн цагдаагийн тасаг зохион байгуулж сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад зөвлөмж танилцуулж баталгаа гаргуулан гарын үсэг зуруулсан.



СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ

Цагдаагийн газрын 2018 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 2018.03.01-ний өдөр “Ахмадаасаа суралцъя” арга хэмжээг зохион байгуулж тус цагдаагийн газарт цагдаа жолоочоор олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан цагдаагийн ахмад ажилтан Б.Шоовдор оролцож шинэ залуу алба хаагч, жолооч нарт үнэтэй сургаал, зөвлөгөө өгч, ажлын баялаг туршлагаасаа хуваалцлаа.



- Эх орончдын өдөр, ОУ-ын эмэгтэйчүүдийн баяр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан тасаг албадын дунд “Цэрэг эх орон”, “Эхийн тухай”, “Цагдаа, дотоодын цэргийн холбогдолтой дуу”-ны уралдааныг 2018.03.02-ны өдөр аймгийн ХГБХХ, “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театртай хамтран аймгийн хүүхдийн ордонд зохион явууллаа. Мөн байгууллагын аварга шалгаруулах Сагсан бөмбөг, ширээний теннис, биллярдын тэмцээнийг зохион байгуулсан. Монгол цэргийн өдөрт зориулсан “Марш тактик-2018” тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байранд шалгарсан.



